“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”-д


**“БиДиСЕК ҮЦК” ХК**

Андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Залуучуудын өргөн чөлөө-27/1
Утас: 11-313108, Факс: 11-323411
www.bdsec.mn


Огноо 2020.04.06 Дугаар 20/107

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Манай компани Хувьцаа эзэмшигчлийн ээлжит хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн 10 цагт Цэнтрал Тауэр (Central Tower)-ын 419 тоот хурлын танхимд хийхээр төлөвлөж холбогдох шийдвэрийг танай байгууллагад хүргүүлсэн билээ.

Гэвч, Улсын онцсой комиссын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэр, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу манай компани энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа цахим хэлбэрээр зохион байгуулахаар болсон тул Монголын Хөрөнгийн Биржийн сайтад байршуулсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын зард өөрчлөлт оруулж өгч бидний ажилд туслана уу.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг шинэчлэн хүргүүлэв.

ХҮНДЭТГЭСЭН

МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер, дилерийн
“БИДИСЕК”
ҮЦК ХК

Д.ДАЯНБИЛГҮҮН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

## "БИДИСЕК ҮЦК" ХК- ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Дэлхий нийтэд өндөр хурдацтай тархаж байгаа "COVID-19"-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, терийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгах 102 дугаар тоот тогтоолыг Монгол Улсын Засгийн Газар 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан билээ. Онцгой нөхцөл байдал үүссэн тул "Монголын хөрөнгийн бирж" ХК-д бүртгэлтэй хувьцаат компаниуд нь хуульд заасан хугацаанд ээлжит хурлаа хувьцаа эзэмшигчдийг биеэр оролцуулан нэг дор зарлан хуралдуулах боломжгүй болоод байгаа билээ.

Улмаар БиДиСЕК ҮЦК ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2020 оны 04-р сарын 20-ний өдрийн 10.00 цагт Цэнтрал Тоуэр (Central Tower)-ын 419 тоот хурлын танхимд зохион байгуулахаар товлосон боловч үүсээд буй нөхцөл байдал мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны гаргасан зөвлөмж, чиглэлийн дагуу бид хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2020 оны 04-р сарын 20-ний өдрийн 10.00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

**ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД** :

a) Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
b) Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
c) Компани ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ–н гаргасан шийдвэрийг танилцуулах
d) ТУЗ-ийн 2020 оны төсөв батлах
e) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

УТАС: 75551919, 99043164